

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2026 ОНЫ ХАГАС
ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН**

2026.05.30

1. Сургалтын нэгдсэн тайлан

Хүснэгт 1. Сургалтын нэгдсэн тайлан

№	Сургалтын төрөл	Сургалтын тоо	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Хамрагдсан ажилтны тоо	Төлөвлөгөөний биелэлтийн хувь
1	2	3	4	5	6
1	Төлөвлөгөөт сургалт	17	1	55	5.9%
2	Төлөвлөгөөт бус сургалт	4	4	82	100%
3	Шинэ ажилтны чиглүүлэх сургалт	1	1	16	100%
НИЙТ				153	68.6%

2. Төлөвлөгөөт сургалтын хүснэгтэн тайлан

Хүснэгт 2. Сургалтын дэлгэрэнгүй тайлан

№	Сургалтын төрөл	Сургалтын нэр	Сургалтын хугацаа		Хамрагдсан ажилтны тоо
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	2	3	4	5	6
1. Төлөвлөгөөт сургалт					
1	Чадавхжуулах сургалт	Албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил	3 сар	3 сар	55
2	Чиглүүлэх сургалт	Шинэ ажилтны чиглүүлэх сургалт	1-6 сар	1-6 сар	16
НИЙТ					71
2. Төлөвлөгөөт бус сургалт					
1	ХАБЭА сургалт	ХАБЭА-н хууль тогтоомж, стандартуудын хэрэгжилт	4 сар	20 хүн	622 /Давхардсан тоогоор/
		Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ба	1-5 сар	41 хүн	

		эрсдэлийг бууруулах арга хэмжээ			
		Гэнэтийн осол, гал түймэр, байгалийн гамшгийн үед авах арга хэмжээ	1-5 сар	41 хүн	
		Хамгаалах хувцас, хэрэгслийн зөв хэрэглээ	1-5 сар	89 хүн	
		Монгол Улсад мөрдөж буй ХАБЭА-н хууль, журам, стандартын үндсэн шаардлагын танилцуулга	1-5 сар	89 хүн	
		Гүйцэтгэгч талын ХАБЭА-тай холбоотой хариуцлага, үүргийг тодорхой болгох	1-5 сар	102 хүн	
		Хөдөлгөөн, тээврийн аюулгүй ажиллагааг сайжруулах арга хэмжээнүүд	1-5 сар	120 хүн	
		Зөрчил гарсан тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагын талаар мэдээлэл өгөх	1-5 сар	120 хүн	
2	Хөгжүүлэх сургалт	"Office-365" программын сургалт	2026.01.13	1 цаг	18
3	Хөгжүүлэх сургалт	ISO 9001:2016 стандарт чанарын менежментийн тогтолцоо шаардлага танилцуулга	2026.02.06- 02.07	2 хоног	74

		сургалт болон хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сургалт			
НИЙТ					166

3. Сургалтын төрлийн талаарх дэлгэрэнгүй тайлан

Хүснэгт 4. Хагас жилийн сургалтын дэлгэрэнгүй тайлан

№	Сургалтын төрөл	Сургалтын төрөл	Хамрагдсан ажилтны тоо /Давхардсан тоогоор/
1	2	3	4
1	Чадавхжуулах сургалт	1	55
2	Мэргэшүүлэх сургалт	-	-
3	Хөгжүүлэх сургалт	1	74
4	Чиглүүлэх сургалт	1	16
5	ХАБЭА сургалт	1	622
6	Гадаад сургалт	-	-
Нийт		7	771

2026 ОНЫ ХАГАС ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

1.1. Чиглүүлэх сургалт

Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон сургалтын журамд тус тус заасны дагуу ажилтны чиглүүлэх сургалтад 16 ажилтныг хамруулсан. Шинэ ажилтны чиглүүлэх сургалт нь байгууллагад шинээр ажилд орсон болон албан тушаал өөрчлөгдсөн ажилтныг богино хугацаанд ажлын орчиндоо дасан зохицож, компанийн бодлого, журам, аюулгүй ажиллагаа болон байгууллагын соёлын талаар цэгцтэй, иж бүрэн ойлголт авах нөхцөлөөр хангах зорилготой сургалтын үйл ажиллагаа юм.

Оролцоо үр дүн: Шинэ ажилтны чиглүүлэх сургалтын хүрээнд нийт 16 ажилтныг чиглүүлэх сургалтад хамрууллаа.

Сургалтын хамрах хүрээ:

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт;
- Компанийн танилцуулга, үнэт зүйл, түүх, соёл;
- Хөдөлмөрийн дотоод журам, ажилтны эрх ба үүрэг;
- ХАБЭА-н урьдчилсан зааварчилгаа;
- Ажил үүргийн чиглэлийн ерөнхий танилцуулга;

Оролцогчдын идэвх:

- ✓ Асуулт, хариултын хэсэгт идэвхтэй оролцсон;
- ✓ Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд анхааралтай хандсан;
- ✓ Байгууллагын нийтлэг дүрэм, соёлын талаарх ойлголтоо бататгасан.

Шинэ мэдлэг, туршлага: Шинэ ажилтны чиглүүлэх сургалт нь ажилтныг богино хугацаанд байгууллагын ажиллагаа, соёлд дасан зохицож, ажил үүргээ үр бүтээлтэй, аюулгүйгээр гүйцэтгэхэд шаардлагатай суурь мэдлэг, дадал, хандлагыг суулгах сургалт юм.

Зураг.1 Сургалтын үеийн зураг



1.2. Microsoft office-365 программ ашиглалтын талаарх сургалт

Microsoft Office 365 программ нь байгууллагын өдөр тутмын ажлыг цахимжуулж, илүү хурдан, уян хатан зохион байгуулах боломжийг олгодог үүлэн технологид суурилсан үйлдвэрлэлийн багц программ юм. Word, Excel, PowerPoint, Outlook зэрэг үндсэн хэрэгслүүдээс гадна Teams, OneDrive, SharePoint зэрэг хамтын ажиллагааны орчнуудтай тул ажилтнууд баримт бичиг дээр зэрэг ажиллах, онлайн хурал зохион байгуулах, мэдээлэл солилцох боломжтой. Мөн бүх төхөөрөмжөөс хаанаас ч нэвтрэн ажиллах давуу талтай тул хөдөлмөрийн бүтээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ. Аюулгүй байдлын өндөр түвшний хамгаалалттай учраас байгууллагын мэдээллийг найдвартай хадгалж, удирдах боломжийг бүрдүүлдэг. Microsoft Office 365 программыг компанийн дотоод үйл ажиллагааг оновчтой болгох, багийн хамтын ажиллагааг түргэсгэхийн тулд хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтын талаар нийт ажилчдыг сургалтад хамруулан ажиллаж байна.

1.3 Чанарын менежментийн тогтолцоо шаардлага MNS ISO 9001:2016 стандарт болон хөдөлмөр эрүүл мэнд аюулгүй ажиллагааны сургалт

MNS ISO 9001:2016 нь байгууллагын чанарын менежментийн тогтолцоонд тавих олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг тогтоодог стандарт юм. Энэхүү стандартын гол зорилго нь байгууллага хэрэглэгчийн хэрэгцээ, хууль эрх зүйн шаардлагыг хангахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээний тогтвортой, чанартай

нийлүүлэх чадамжийг бий болгох, улмаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.

ISO 9001:2016 стандартыг хэрэгжүүлэх нь:

- Байгууллагын дотоод үйл явцын үр нөлөөг дээшлүүлэх,
- Хэрэглэгчийн хүлээлтэд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх,
- Байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх практик ач холбогдолтой гэж сургалтын мэдээллүүдэд дурдсан байдаг.

ISO 9001:2016 стандарт нь бүх төрлийн байгууллагад нийцэж болох уян хатан бүтэцтэй бөгөөд процессын удирдлага, эрсдэлийн сэтгэлгээ, тасралтгүй сайжруулалтын зарчимд тулгуурладаг.

Оролцоо үр, дүн: Чанарын менежментийн тогтолцоо шаардлага MNS ISO 9001:2016 стандарт болон хөдөлмөр эрүүл мэнд аюулгүй ажиллагааны сургалтын хүрээнд нийт 74 ажилтан сургалтад хамрагдсан.

Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/24 тушаалын хэрэгжилтийн хүрээнд ажлын хэсэг болон ажлын төлөвлөгөө гарган MNS ISO 9001:2016 нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган 7 хоног бүрийн пүрэв гарагт ажлын хэсгийн бүрэлдэхүүн сургалтад хамрагдан ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэхээр ажиллаж байна.





1.4. Албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил сургалт

Компанийн “Сургалтын төлөвлөгөө”-нд тусгагдсан хууль эрх, зүйн сургалтын хүрээнд ажилтнуудын авлигын гэмт хэрэг, албан тушаалын давуу байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор уг сургалтыг зохион байгуулсан.

Сургалтанд “Шударга нийгмийн төлөө хамтдаа” НҮТББ-ын эрхзүйн шинжлэх ухааны докторант Б.Тэрбиш хүрэлцэн ирж авлигын гэмт хэрэг, түүний шинж чанар, ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрийн талаар эрх зүйн байдлыг практик жишээгээр тайлбарлаж, одоо мөрдөгдөж буй хууль, дүрэм, эрх зүйн баримт бичгүүдэд оруулсан өөрчлөлт, шинэчлэлийн талаар мэдээлэл өгсөн.

Хамгийн чухал нь хувь хүн хуулийн мэдлэгтэй байснаар өөрийгөө түүнчлэн байгууллага сайн хуулийн мэргэжилтэн, багтай байснаар байгууллагын үйл ажиллагаанд үүсч болох авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, эрсдэлийг эрт шатанд илрүүлэх, урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтойг онцолсон. Тус сургалтад удирдах болон гүйцэтгэх шатны нийт 55 орчим ажилтан хамрагдсан.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтын хүрээнд давхардсан тоогоор нийт 223 албан хаагч, ажилчдыг сургалтад хамруулан ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрын 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 01/357 дугаар албан бичгийн дагуу төсвийн сахилга батыг сайжруулж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, хэмнэлт гарган ажиллах чиглэлийн дагуу сургалтын үйл ажиллагааг түр зогсоогоод байна.